

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/25

Арвайхээр

Коронавируст халдвар (ковид-19)-ын эсрэг  
“комирнэти” (BNT162b2) вакцинаар  
дархлаажуулах тухай

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг “Комирнэти” (BNT162b2) вакцинаар дархлаажуулах тухай” А/378 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Пфайзер -БиоН”Тех үйлдвэрийн “Комирнэти” (BNT162b2) хүүхдийн вакцинаар зааврын дагуу сайн дурын үндсэн дээр эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг үндэслэн 5-11 насны хүүхдийг хоорондоо нэг сарын зайтай 2 тунгаар вакцинжуулах арга хэмжээг 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулсугай.

2. Зорилтот насны хүүхдийг вакцинжуулах арга хэмжээг зохион байгуулах, вакцинжуулалт эхлэхээс өмнө дархлаажуулалтын нэгжид ажиллах эмч, эрүүл мэндийн ажилчдыг сургалтад хамруулах, мэргэжлийн удирдлаар ханган ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга (М.Золзаяа), хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчаас урьдчилан зөвшөөрөл авч вакцинжуулах, дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийг бүртгэх, мэдээлэх, тандах журмын хэрэгжилтийг чанд мөрдөн ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ